



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар A/21

Улаанбаатар хот

**Эмийн эмчилгээний хороо болон
бичил биетний эсрэг эмийн дэд хорооны
ажиллах журмыг шинэчлэн батлах тухай**

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 30.2 дугаар зүйл, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эмнэлэгт “Эмийн эмчилгээний хороо болон бичил биетний эсрэг эмийн дэд хорооны”-ны ажиллах журмыг нэгдүгээр, эмнэлгийн эмийн хэрэглээний мэдээний маягтыг хоёрдугаар, эмнэлгийн бичил биетний эсрэг эмийн хэрэглээний мэдээний маягтыг гуравдугаар, эмнэлэгт тухайн жилд хэрэглэгдсэн бичил биетний эсрэг эмийн жагсаалтыг дөрөвдүгээр, эмнэлгийн тэсвэржсэн бичил биетний мэдээний маягтыг тавдугаар, хороо болон дэд хорооны үйл ажиллагааны тайлангийн маягтыг зургаадугаар, эмийн эмчилгээний хорооны үйл ажиллагааг үнэлэх шалгуурыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эмийн эмчилгээний хороо болон бичил биетний эсрэг эмийн дэд хороог шинэчлэн зохион байгуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, амаржих газрын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Эмийн эмчилгээг тасралтгүй, жигд, оновчтой төлөвлөж, эмчилгээний өндөр идэвхтэй, чанарын баталгаатай эмийн сонголт, хангамжийг сайжруулах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, сувилал, хувийн хэвшлийн эмнэлгийн дарга нарт үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

5.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



П.АЛТАНЦЭЦЭГ

1525 010028
ХЯНГАЛ
ХАВР

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20²⁵ оны 02 дугаар сарын 13 -ны
өдрийн 21 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
128



ЭМИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХОРОО БОЛОН БИЧИЛ БИЕТНИЙ ЭСРЭГ ЭМИЙН ДЭД ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Эмнэлэгт эмийн эмчилгээний хороо (цаашид “хороо” гэх) болон бичил биетний эсрэг эмийн дэд хорооны (цаашид “дэд хороо” гэх) ажиллах бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Хороо болон дэд хорооны зорилго нь эмнэлэгт үйлчлүүлэгч эдийн засгийн үр ашигтай, чанартай, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлүүлэх тогтолцоог хангах, эмийн сонголт, түгээлт, хадгалалт, хэрэглээ, хангамж хүртээмжид хяналт тавих, бичил биетний тэсвэржилтийг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэх, мэдрэг чанарын зүй тогтлыг тандах, судлах, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахад оршино.

1.3.Хороо болон дэд хороо нь “Эрүүл мэндийн тухай хууль”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль” тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичиг, бусад хууль тогтоомж, стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

1.4.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, амаржих газарт эмийн эмчилгээний хороо болон бичил биетний эсрэг эмийн дэд хороо ажиллана.

1.5.Эмийн эмчилгээний хороо болон дэд хороогүй өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, сувилал, энэхүү журмын 1.4-т зааснаас бусад эрүүл мэндийн байгууллага эмийн эмчилгээг тасралтгүй, жигд, оновчтой төлөвлөж, эмчилгээний өндөр идэвхтэй, чанарын баталгаатай эмийн сонголт, хангамжийг сайжруулах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.

1.6.Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь эмийн эмчилгээний хороогүй өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэж байгаа эм, биозбэлдмэлийн чанар, аюулгүй байдалд хяналт тавих, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мэдээлэл сургалт зохион байгуулах, үйл ажиллагаанд нь арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1.Эмнэлгийн хүчин чадал, хүний нөөцөөс хамааран хорооны бүрэлдэхүүн нь дараах гишүүдээс бүрдэнэ. Үүнд:

2.1.1.эмийн эмчилгээний хороо нь эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, эмнэлзүйн эм судлаач, эмнэлзүйн эм зүйч, чанарын албаны дарга, тасгийн эрхлэгч, лабораторийн болон нян судлаач эмч, халдвар судлаач эмч, статистикч эмч, бусад төрөлжсөн мэргэшлийн их эмч нарын төлөөлөл, сувилахуйн арга зүйч, санхүүгийн удирдах ажилтан зэрэг төлөөлөл бүхий 7-оос доошгүй гишүүдээс бүрдэнэ.

2.1.2.эмийн эмчилгээний хороог эмчилгээ эрхэлсэн орлогч дарга тэргүүлэх бөгөөд нарийн бичгийн даргаар эм зүйн албаны дарга, эсхүл мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан эм зүйч ажиллана.

2.2.Хороо нь дэргэдээ бичил биетний тэсвэржилттэй тэмцэх хөтөлбөрийг өөрийн эмнэлгийн нөхцөлд тохируулан боловсруулж, хэрэгжүүлэх “Бичил биетний эсрэг эмийн дэд хороо”-той байна.

2.2.1.бичил биетний эсрэг эмийн дэд хороо нь халдвар судлаач эмч, төрөлжсөн мэргэшлийн их эмч, эмнэлзүйн эмгэг судлаач эмч эсвэл био-анагаахын мэргэжилтэн, эмнэлзүйн эм зүйч болон чанарын менежер, сувилахуйн албаны төлөөлөл бүхий 5-аас доошгүй гишүүдээс бүрдэнэ.

2.2.2.бичил биетний эсрэг эмийн дэд хорооны ахлагч нь эмнэлзүйн эм зүйч байх бөгөөд эмийн эмчилгээний хорооны гишүүн байна.

2.3.Эмийн эмчилгээний хороо, дэд хорооны гишүүдийн журамд заасан чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусгаж оруулна.

2.4.Эмийн эмчилгээний хороо болон дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг эмнэлгийн дарга баталж, шаардагдах зардлыг жил бүр төсөвт тусган, санхүүжүүлнэ.

Гурав. Эмийн эмчилгээний хорооны чиг үүрэг

3.1.Эмийн чанар, аюулгүй байдал, эмчилгээний идэвх, хүртээмж, төлөвлөлт, үр дүнг судлах, хянах, үнэлэх,

3.2.Эмийн хэрэглээтэй холбоотой тохиолдож болзошгүй эрсдэл, эмчилгээний алдаа дутагдлаас сэргийлэх, түүнийг арилгах арга хэмжээг зохион байгуулах;

3.3.Бичил биетний эсрэг эмийн дэд хороог удирдлага арга зүйгээр хангах, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих;

3.4.Гаж нөлөө үүсгэх өндөр эрсдэлтэй эмийн жагсаалтыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний онцлогтоо тохируулан гаргаж, жагсаалтад орсон эмийн гаж нөлөө илэрсэн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны заавар боловсруулан баталж, мөрдүүлэх;

3.5.Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох журмын дагуу эмийн гаж нөлөөний мэдээллийг хэлэлцэж, дүнг эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

3.6.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ эм нэвтрүүлэх, нотолгоонд суурилан сонгох, эмчилгээнд хэрэглэж байсан эмийг ижил үйлчилгээтэй эмээр солих, зарим эмийн хэрэглээнд нас, тунгийн хязгаарлалт хийх, эмчилгээний үр дүнгүй эмийг эмчилгээнээс хасах тохиолдолд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт мэдээлэх, шаардлагатай тохиолдолд Хүний эмийн зөвлөлд асуудал дэвшүүлэх;

3.7.Эмийн эмчилгээний үр дүнг тооцон эмийн хэрэглээг үнэлэх (ABC, VEN, DDD, PPS аргачлалын дагуу), эмчилгээний болон эдийн засгийн үр ашиггүй хэрэглээг бууруулах, эмийн үнэ, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хяналт, судалгааг хийн, үр дүнг байгууллагын удирдлагад жил бүрийн 12 сард тайлагнах;

3.8.Тухайн эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эмийн жагсаалтыг зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад үндэслэн боловсруулах, батлан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

3.9.Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх аргачлал, гарын авлага, удирдамж боловсруулах, батлан мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

3.10.Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг сайжруулахад чиглэсэн дотоод тандалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, үр дүнг сайжруулах, хяналт тавьж ажиллах;

3.11.Төндөрээр болон гэрээт байдлаар худалдан авч байгаа эмийн сонголт, чанар, зарцуулалт, гэрээний хэрэгжилтэд улирал бүр хяналт тавих, биелэлтийг үнэлэх, байгууллагын удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлэх;

3.12.Эмийн эмчилгээний тасалдлыг хянах, үйлчлүүлэгчээр авчруулж эмчилгээнд хэрэглэсэн эмийг эргүүлэн төлөх асуудлыг байгууллагын удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлэх;

3.13.Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн эмнэлзүйн заавар удирдамжид санал өгөх, мөрдүүлэх;

3.14.Эмийн чанар, аюулгүй байдал, эмчилгээний идэвх тодорхойлох судалгааг холбогдох байгууллагатай хамтран хийх;

3.15.Эмнэлгийн мэргэжилтнийг шинэ эмийн мэдээллээр хангах, эмийн эмчилгээг оновчтой, эдийн засгийн үр ашигтай, үр дүнтэй төлөвлөх чадварыг бий болгох ажлыг зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах;

3.16.Эмийн эмчилгээний хорооны үйл ажиллагаа, шийдвэр, зөвлөмжийг удирдлага, эмч, мэргэжилтэнд ил тод нээлттэй хүргүүлэх, өөрийн үйл ажиллагааг хавсралтын дагуу үнэлэх;

3.17.Хорооны үйл ажиллагааг гүйцэтгэхэд эмнэлгийн эмч мэргэжилтэнг татан оролцуулах;

3.18.Эмнэлэгт эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар санал, зөвлөмж гаргах, сургалт, сурталчилгаа, мэдээлэл хийх, орон нутаг болон байгууллагын хурал, зөвлөгөөн, ярилцлагад оролцох, зохион байгуулах;

3.19.Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй болон амбулаториор үйлчлүүлэгчдэд эмийн зохистой хэрэглээний талаарх мэдлэг олгох сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

3.20.Эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлал, үйлчлэх хүрээний хүн амын онцлог, зонхилон тохиолдох эмгэг, бичил биетний эсрэг эмийн тэсвэржилтийн байдал зэрэгт уялдуулан тухайн эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эмнэлзүйн удирдамжийг боловсруулан, батлан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих.

Дөрөв. Бичил биетний эсрэг эмийн дэд хорооны чиг үүрэг

4.1.Дэд хорооны нийтлэг чиг үүрэг:

4.1.1.бичил биетний тэсвэржилттэй тэмцэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;

4.1.2.бичил биетний эсрэг эмийн эмчилгээний удирдамж зааврыг бичил биетний эсрэг эмийн бодлоготой уялдуулан нотолгоонд суурилан боловсруулах, шинэчлэх, хэрэгжилтийг тогтмол хянах;

4.1.3.тухайн эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай бичил биетний эсрэг эмийн жагсаалтыг бичил биетний тэсвэржилтийн мэдээлэлд үндэслэн боловсруулах, тогтмол шинэчлэх, батлуулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх;

4.1.4.бичил биетний эсрэг эмийн хэрэглээг тогтмол хянах;

4.1.5.антибиограм боловсруулах, шаардлагатай арга хэмжээг авч, үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд улирал бүр тайлагнах;

4.1.6.бичил биетний эсрэг эмийн хэрэглээ, хамаарлын үнэлгээг хагас бүтэн жилээр хийх ажлыг зохион байгуулах, үр дүнг хороо болон эмнэлгийн удирдлагад тайлагнах;

4.1.7.бичил биетний тэсвэржилтийн судалгааны ажлыг тасралтгүй зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллах;

4.1.8.бичил биетний мэдрэг чанарын зүй тогтлыг судлах, тандах;

4.1.9.эмнэлгийн тусламж үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулахад оролцох;

4.1.10.бичил биетний эсрэг эмэнд тэсвэржилт үүсэхээс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг таслан зогсоох, эрсдэлийг бууруулах, анхаарал татаж буй бичил биетний тэсвэржилтийн хяналтыг сайжруулах талаар салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан мэдээлэл солилцох;

4.1.11.бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээний талаарх эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, дадлага, хандлагыг дээшлүүлэх, холбогдох үйл ажиллагаанд татан оролцуулах;

4.1.12.бичил биетний эсрэг эмийн эмчилгээний үндэслэл, жор бичилтийг сайжруулах сургалтыг зохион байгуулах.

4.2.Бичил биетний эсрэг эмийн асуудал хариуцсан эмнэлзүйн эм зүйч дараах үүрэгтэй:

4.2.1.энэхүү журмын 4.1.1-д заасан хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах;

4.2.2.эмнэлзүйн удирдамж, эмийн эмчилгээ болон бусад холбогдох дүрэм, журам боловсруулахад оролцох,

4.2.3.эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу эмчилгээ хийгдэж буй эсэхэд хяналт тавих;

4.2.4.бичил биетний эсрэг эмийн эмчилгээг хянах, алдааг тандаж илрүүлэх, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4.2.5.хяналттай хэрэглэх бичил биетний эсрэг эмийн жагсаалтыг халдвар судлаач эмч, нян судлаач эмчтэй хамтран боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд үнэлгээ хийх;

4.2.6.бичил биетний эсрэг эмийн эмчилгээг дараах байдлаар зохицуулах;

4.2.6.1.өргөн хүрээний үйлдалттай бичил биетний эсрэг эмээс явцуу хүрээний үйлдэлтэй эмэнд шилжүүлэх;

4.2.6.2.эмийн хэлбэрийг өөрчлөх буюу тарилгын эмийн хэлбэрээс уух хэлбэрт шилжүүлэх;

4.2.6.3.шаардлагагүй бичил биетний эсрэг эмийг зогсоох;

4.2.6.4.хавсарсан эмчилгээний талаар үнэлгээ хийж хянах

4.2.7.бичил биетний эсрэг эмийн хэрэглээ болон тандалтын судалгааг хариуцах;

4.2.8.эмнэлгийн түвшинд тандалтын мэдээ мэдээлэл, тоо баримт гаргах, цуглуулах, мэдээний сан бүрдүүлэх;

4.2.9.эмнэлгийн бичил биетний эсрэг эмийн хэрэгцээ, нөөц бүрдүүлэлтэд шаардлагатай тоо баримт цуглуулж, мэдээний сан бүрдүүлэх, тооцоолол хийхэд оролцох;

4.2.10.эмнэлзүйн удирдамжийн болон эмчилгээний үр дүн, эмчлүүлэгчийн биеийн байдал сайжирсан эсэх, эдийн засаг, санхүү, бичил биетний тэсвэржилтийн байдал, хөдлөл зүйг хянах;

4.2.11.бичил биетний тэсвэржилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багийн бусад гишүүдтэй эмнэлзүйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд хамтарч ажиллах;

4.2.12.эмнэлгийн бичил биетний эсрэг эмийн хэрэглээ, зарцуулалт эмчилгээний талаар эмийн эмчилгээний хороо болон эмч нарт эргэн мэдээлэх.

4.3.Нян судлаач эмч дараах үүрэгтэй:

4.3.1.бичил биетний тэсвэржилтийн шинжилгээг хийх багаж, тоног төхөөрөмж, оношлуур зэргийг хүртээмжтэй байлгах талаар эмнэлгийн удирдлагад мэдээлэх;

4.3.2.антибиограм болон бичил биетний тэсвэржилтийн тандалтын мэдээллийг холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэдээлэх;

4.3.3.бичил биетний эсрэг эмийн мэдрэг чанарын шинжилгээний хариуг WHONET-д программд өдөр бүр мэдээлэх, дүгнэлтийг Үндэсний лавлагаа лаборатори /ХӨСҮТ/-ийн нян судлалын лавлагаа лабораториор баталгаажуулан хүлээн авч, дэд хорооны ахлагчид тухай бүр мэдээлэх;

4.3.4.эмгэг төрөгчийг цаг хугацаанд нь оновчтой тодорхойлж, антибиотикийн мэдрэг чанарын шинжилгээг зохистой хийж гүйцэтгэх;

4.3.5.шаардлагатай тохиолдолд түргэвчилсэн шинжилгээг нэвтрүүлэх;

4.3.6.нян судлал, молекул биологийн шинжилгээгээр үүсгэгчийг болон эмийн тэсвэржилтийг тодорхойлох;

4.3.7.хурдавчилсан оношлуур, биомаркерийн шинжилгээ ашиглан бактерийн болон вирусын халдварыг ялган оношлох;

4.3.8.үжил амь насанд аюултай хүнд халдвар, хүндрэлийг цаг алдалгүй илрүүлэх, мэдээлэх;

4.3.9.антибиотик эмчилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэн ажиллах;

4.3.10.олон эмэнд тэсвэртэй бактер илэрсэн тохиолдол бүрийг дэд хорооны ахлагч, холбогдох мэргэжилтэнд шуурхай мэдээлэх;

4.3.11.бусад шинжилгээтэй харьцуулан таамаг бичил биетний эсрэг эмийн эмчилгээг сонгоход шаардлагатай мэдээ, мэдээллээр эмч, мэргэжилтэнг хангах;

4.3.12.халдвараас урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагаанд хамтран ажиллах.

4.4.Халдвар судлаач эмч болон бусад гишүүд дараах үүрэгтэй:

4.4.1.эмэнд тэсвэртэй бичил биетний халдвараас сэргийлэхтэй холбоотой гарын авлага, удирдамжуудыг бичил биетний тэсвэржилт, хөдлөл зүйтэй уялдуулан боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх;

4.4.2.бичил биетний тэсвэржилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

4.4.3.хорооны гишүүдтэй хамтран эмэнд тэсвэртэй бичил биетний халдварын сэргийлэлт, хяналтын талаарх хурал, зөвлөгөөн, ярилцлага, сургалтыг зохион байгуулах, санал, зөвлөмж гаргах.

Тав. Эмийн эмчилгээний хорооны тайлан мэдээг ирүүлэх

5.1.Тусгай зөвшөөрөл бүхий өмчийн бүх хэлбэрийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, амаржих газрын эмийн эмчилгээний хороо нь эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр дотооддоо гаргаж, тушаалын хавсралтаар баталсан маягтуудын дагуу бүтэн жилээр тайлан болон үнэлгээг нэгтгэн гаргаж, эмнэлгийн тэмдгээр баталгаажуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор mmra@gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Зургаа. Эмийн эмчилгээний хороо болон бичил биетний эсрэг эмийн дэд хорооны үйл ажиллагааг үнэлэх, зохицуулах


6.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын холбогдох нэгж Эмийн эмчилгээний хороо болон бичил биетний эсрэг эмийн дэд хорооны үйл ажиллагааг дараах байдлаар зохицуулна.

- 6.1.1.хороо, дэд хорооны үйл ажиллагааны тайлан, мэдээ, үнэлгээг нэгтгэн дүгнэх;
- 6.1.2.тайлан, мэдээтэй холбоотой шаардлагатай зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагад эргэн мэдээлж, мэргэжил арга зүйгээр хангах;
- 6.1.3.эмнэлгүүдийн эмийн эмчилгээний хороо, дэд хороотой хамтран хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах;
- 6.1.4.хороо, дэд хорооны үйл ажиллагааг үнэлэх;
- 6.1.5.энэхүү журмын хэрэгжилтийн талаарх мэдээллийг холбогдох дээд шатны байгууллага болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн магадлан итгэмжлэлийн албанд хүргүүлэх.

Долоо. Хариуцлага

7.1.Энэхүү журамд заасныг зөрчиж худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан, тогтоосон хугацаанд тайланг ирүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20²⁵ оны 11 дугаар сарын 12-ны
өдрийн 11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
128



ЭМНЭЛГИЙН ЭМИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭ

Эмнэлгийн нэр:

..... он

№	Үзүүлэлт	Тоо	Хувь
1	Нийт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо	*	
2	Дундаж ор хоног /эмчлүүлсэн хугацаа/	*	
3	Эмчилгээнд нэг зэрэг хэрэглэсэн эмийн нэр төрлийн дундаж тоо	*	
4	Эмчилгээнд хэрэглэсэн нийт бичил биетний эсрэг эмийн эзлэх хувь (бактер, вирус, мөөгөнцрийн, шимэгчийн эсрэг эм) нэр төрөл тус бүрээр	Нийт	*
		бактер	*
		вирус	*
		мөөгөнцөр	*
		шимэгч	*
5	Нийт хэрэглэсэн эмэнд тарилгын эмийн эзлэх хувь		*
6	Нийт хэрэглэсэн эмэнд зайлшгүй шаардлагатай эмийн эзлэх хувь		*
7	Нийт хэрэглэсэн эмэнд илэрсэн гаж нөлөөний тоо	*	
8	Эмчилгээ оношилгооны удирдамжийн дагуу эмчилгээнд хэрэглэсэн эмийн эзлэх хувь		*
9	Хэвтэн эмчлүүлэх хугацаанд хэрэглэсэн эмийн дундаж үнэ /1 эмчлүүлэгчид/	*	

(*) тэмдэглэсэн хэсэгт бөглөж бичнэ.

Эмийн хэрэглээний мэдээ


гаргасан хүний овог, нэр:

Албан тушаалын нэр:

Холбогдох утасны дугаар,

цахим шуудан:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20.25 оны 62 дугаар сарын 13-ны
өдрийн А/ дугаар тушаалын гуравдугаар хавсралт
128



ЭМНЭЛГИЙН БИЧИЛ БИЕТНИЙ ЭСРЭГ ЭМИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭ

Эмнэлгийн нэр:

..... он

№	Үзүүлэлт	Нийт	Тоо	Хувь
1	Бичил биетний эсрэг эм хэрэглэсэн нийт үйлчлүүлэгчийн тоо	бактер	*	*
		вирус	*	*
		мөөгөнцөр	*	*
		шимэгч	*	*
2	Бичил биетний эсрэг эм хэрэглэхээс өмнөх мэдрэг чанар тодорхойлсон шинжилгээний нийт тоо		*	
3	Тарилга хэлбэрээр хэрэглэсэн бичил биетний эсрэг эмийн эзлэх хувь			*
4	Бичил биетний эсрэг эмэнд илэрсэн гаж нөлөөний тоо		*	
5	Нэг үйлчлүүлэгчид хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн бичил биетний эсрэг эмийн НЭР ТӨРЛИЙН дундаж тоо		*	
6	Бичил биетний эсрэг эмийн эмчилгээний дундаж хугацаа		*	
7	Бичил биетний эсрэг эмийн эмчилгээнд тарилгын хэлбэрээс уух хэлбэр лүү шилжүүлсэн өвчтөний тоо		*	
8	Урьдчилан сэргийлэх зорилгоор бичил биетний эсрэг эм хэрэглэсэн ӨВЧТӨНИЙ ТОО	Нийт	*	*
		бактер	*	*
		вирус	*	*
		мөөгөнцөр	*	*
		шимэгч	*	*
9	Урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэсэн бичил биетний эсрэг ЭМИЙН ТОО		*	
10	Урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэсэн бичил биетний эсрэг эмийн ДУНДАЖ ХУГАЦАА		*	

(*) тэмдэглэсэн хэсэгт бөглөж бичнэ.

Эмийн хэрэглээний мэдээ


гаргасан хүний овог, нэр:

Албан тушаалын нэр:

Холбогдох утасны дугаар,

цахим шуудан:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны
өдрийн 1/ дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт
/23



ЭМНЭЛЭГТ ТУХАЙН ЖИЛД ХЭРЭГЛЭГДСЭН
БИЧИЛ БИЕТНИЙ ЭСРЭГ ЭМИЙН ЖАГСААЛТ

АТС код	Эмийн ОУ-ын нэршил	Эмийн худалдааны нэршил	Хэрэглэсэн арга	Эмийн тун	Хэрэглэсэн тоо ширхэг /шахмал, капсул, туншил гм/
Бактерийн эсрэг эм					
J01GB06	Амикацин				
J01CA04	Амоксициллин		уух		
J01CA04	Амоксициллин		тарилга		
J01CR02	Амоксициллин ферментийн хориглогч		уух		
J01CR02	Амоксициллин ферментийн хориглогч		тарилга		
J01CA01	Ампициллин		уух		
J01CR01	Ампициллин		тарилга		
J01CR01	Ампициллин/сулбактам				
J01FA10	Азитромицин				
J01CE08	Бензатин пенициллин				
J01CE01	Бензилпенициллин				
J01DB04	Цефазолин				
J01DE01	Цефепим				
J01DC04	Цефаклор				
J01DB05	Цефадроксил				
J01DB01	Цефалексин				
J01DD15	Цефдинир				
J01DD08	Цефиксим				
J01DD01	Цефотаксим				
J01DE02	Цефпиром				

J01DD02	Цефтазидим				
J01DD04	Цефтриаксон				
J01DC02	Цефуросим		уух		
J01DC02	Цефуросим		тарилга		
J01BA01	Хлорамфеникол		уух		
J01BA01	Хлорамфеникол		тарилга		
J01MA02	Ципрофлоксацин		уух		
J01MA02	Ципрофлоксацин		тарилга		
A07AA10	Колистин		уух		
J01XB01	Колистин локсациллин		тарилга		
J01FA09	Кларитромицин				
J01FF01	Клиндамицин				
J01DH04	Дорипенем				
J01AA02	Доксициклин				
J01FA01	Эритромицин				
J01XX01	Фосфомицин		уух/ тарилга		
J01GB03	Гентамицин				
J01DH51	Имипенем/циластин				
J01FA07	Джозамицин				
J01GB04	Канамицин		тарилга		
J01MA12	Левифлоксацин		уух		
J01MA12	Левифлоксацин		тарилга		
J01XX08	Линезолид				
J01DH13	Меропенем				
J01XD01	Метронидазол		уух		
J01XD01	Метронидазол		тарилга		
J01FA03	Мидекамицин		уух		
J01FA03	Мидекамицин		тарилга		
J01MA14	Моксифлоксацин				
J01XE01	Нитрофурантоин				
J01MA06	Норфлоксацин				
J01MA01	Офлоксацин				
P01AB03/ J01XD03	Орнидазол		уух/ тарилга		

J01CR05	Пиперацилин/тазобактам				
J04AB02	Рифампицин				
A07AA11	Рифаксимин				
J01FA06	Рокситромицин				
J01XX04	Спектиномицин				
J01EE01	Сульфаметоксазол/тримет оприм				
J01XA02	Тейкопланин				
P01AB02	Тинидазол		уух		
J01XD02	Тинидазол		тарилга		
A07AA09	Ванкомицин		уух		
J01XA01	Ванкомицин		тарилга		
	бусад				
Мөөгөнцрийн эсрэг эм					
J02AC03	вориконазол				
G01AF15	бутоконазол				
A07AA02	нистатин				
G01AF02	клотримазол				
J02AC01	флуконазол				
J02AC02	итраконазол				
	бусад				
Вирусын эсрэг эм					
J05AB01	ацикловир				
J05AB11	валацикловир				
J05AF05	ламивудин				
J05AG01	невирапин				
J05AF07/ J05AF13	тенофовир				
J05AF10	энтекавир				
J05AH02	осельтамивир				
J05AP01	рибавирин				
L03AB12	хүний цэвэршүүлсэн гамма интерфероны эсрэг бие				
L03AB05	интерферон альфа2b				
L03AB61	пегинтерферон альфа (2a, 2b)				
J05AX05	инозин паранобекс				
	интерфероны индуктор				
	бусад				
Шимэгчийн эсрэг эм					
P02CA01	мебендазол				
P02CA03	албендазол				
O2CC01	пирантел				
P02BA01	празикуантил				
	бусад				

Тайлбар: Дээрх жагсаалтад ороогүй бактер, мөөгөнцөр, вирус, шимэгчийн эсрэг хэрэглэсэн эмийн нэрийг нэмж бичнэ.

**Бичил биетний эсрэг эмийн
хэрэглээний мэдээ гаргасан
хүний овог, нэр:**

Албан тушаалын нэр:

**Холбогдох утасны дугаар,
цахим шуудан :**



Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 4/ дугаар тушаалын тавдугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ТЭСВЭРЖСЭН БИЧИЛ БИЕТНИЙ ТАЛААРХ МЭДЭЭ

Тасаг нэгж: (нийт эсвэл ЭЭТ гэх мэт) Сорьцны төрөл: (шээс гэх мэт) Бичил биетэн: (E.coli гэх мэт)

Эмийн нэр	Эмийн код	Тоо	Тэсвэргүй (R%)	Дунд мэдрэг (I%)	Мэдрэг (S%)	Тодорхойгүй (%)?	%R 95%C.I.	%S 95%C.I.
1	2	3	4	5	6	7	8	9
Ампицилин*	AMP	69	75.4	0.0	24.6		63.3-84.6	15.4-36.7
Ципрофлоксацин*	CIP	70	54.3	25.7	20.0		42.0-66.1	11.7-31.6

Тайлбар:


- Нийт тоогоор, амбулаторийн, эрчимт эмчилгээ, хөөдрын, нярайн тасаг гэх мэт тасаг нэгжээр цус болон ТНШ-д S.aureus, S.pneumoniae, E.faecalis, E.faecium, E.coli, K.pneumoniae, Acinetobacter spp., Salmonella spp., P.aeruginosa, N.meningitidis, H.influenzae;
- АДОЗ-ын сорьцонд S.pneumoniae, H.influenzae, S.aureus, Acinetobacter spp., E.coli, K.pneumoniae, P.aeruginosa; өтгөөнд Salmonella spp., Shigella spp.;
- шээсэнд E.coli, K.pneumoniae, Acinetobacter spp., P.aeruginosa; шарханд S.aureus, E.faecalis, E.faecium, E.coli, K.pneumoniae, Acinetobacter spp., P.aeruginosa; ШБЗ-ын сорьцонд N.gonorrhoeae гэх мэт.

*Загаар, жишээ

Мэдээ гаргасан хүний

овог нэр:
Албан тушаалын нэр:
Холбогдох утасны дугаар, цахим шуудан:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20.25 оны 28 дугаар сарын 13-ны
өдрийн 11 дугаар тушаалын зургаадугаар хавсралт
128



ЭМИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХОРООНЫ ТАЙЛАН

Эмнэлгийн нэр:

..... он

Эмийн эмчилгээний хорооны удирдлага, зохион байгуулалтын талаарх
товч танилцуулгыг бичих.

№	Үйл ажиллагааны чиглэл	Хийсэн ажил	Хүрсэн үр дүн	Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгарсан бэрхшээл
1	Эм зүйн тусламж үйлчилгээнд чанар аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулан батлуулж, дүн шинжилгээ хийж ажиллах. Чанар: Бүртгэлгүй эм, хадгалах хугацаа дууссан, анхдагч савлалт гэмтсэн, нүдэнд харагдах өөрчлөлт бүхий зэрэг чанарын асуудалтай эмийн бүртгэл мэдээлэл г.м Аюулгүй байдал: Гаж нөлөө үзүүлсэн эмийн бүртгэл мэдээлэл, Эмийн эмчилгээний алдааны бүртгэл, шалтгаан, авсан арга хэмжээний мэдээлэл г.м			
2	Өндөр эрсдэлтэй эм, ижил харагддаг, ижил дуудагддаг, мансууруулах сэтгэц нөлөөт эмүүдийн хэрэглээнд тасаг, нэгжид хяналт тавих, эмч эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил арга зүйгээр хангах.			
3	Мансууруулах сэтгэц нөлөөт эмийн хэрэгцээ, хэрэглээнд хяналт тавих.			
4	Эм зүйн тусламж, үйлчилгээний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, дүнг удирдлагын зөвлөлөөр			

	хэлэлцүүлэн, арга хэмжээ авч ажиллах.			
5	Эмнэлгийн эмийн жагсаалт дахь эмийн тоо, жагсаалтын бус эмийн хэрэглээний мэдээллийг гаргах, шалтгааныг тодорхойлох.			
6	Эмийн үйлдвэрлэгчээс заасан хадгалалтын нөхцөл мөрдөлт, түүний хяналтыг хийх, (2°C - 8°C , 8°C , - 15°C болон тасалгааны хэмд хадгалдаг эмүүдийн бүртгэлийг хөтлөх)			
7	Эмийн чанартай холбоотой асуудлаар гаргасан үйлчлүүлэгчийн гомдол, саналд дурьдагдсан эмүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл, авсан арга хэмжээ шийдвэрлэсэн байдал.			
8	Өргөн хүрээний үйлдэлтэй бичил биетний эсрэг эмээс явцуу хүрээний үйлдэлтэй эмэнд шилжүүлсэн тухай бүртгэл мэдээлэл хөтлөх. Жнь:Үйлчлүүлэгчийн тоо, илэрсэн бактери, хэрэглэсэн эм, тоо ширхэг, болон хугацаа г.м)			
9	Тухайн жилд хэрэглэгдсэн ЗШЭ-ийн жагсаалтад багтсан эмийн фармакологийн бүлэг, тоо, хэрэглэсэн хувь.			
10	Эмнэлзүйн удирдамжид ороогүй эмийг хэрэглэсэн тохиолдолд хэрэглээг фармакологийн бүлэг, нэр төрөл, тоо, хувь, шалтгааныг дурдах.			
11	Эмнэлэгт хийсэн эмийн таниулах үйл ажиллагааны зохион байгуулалт, бүртгэл хийх.			
12	Эмийн эмчилгээний үр дүн, эмийн хэрэглээ, эмийн эмчилгээний чанар, өртөг зардлын талаар хийсэн үнэлгээ болон судалгааны дүнг хавсаргана. (ABC, VEN, DDD, PPS)			
13	Эмийн зохистой хэрэглээний сургалт, сурталчилгааг улирал бүр			


	зохион байгуулж тайлан мэдээг, нэгтгэж ирүүлэх.			
14	Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах.			
15	Жор бичилтийн дотоод хяналтын шалгуурыг гарган улирал тутам үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авах.			
16	Бичил биетний тэсвэржилттэй тэмцэх батлагдсан төлөвлөгөөний дагуу тайлагнах.			
17	Байгууллагын эрсдэл, тохиолдлын санд бүртгэгдсэн эмийн эмчилгээтэй холбоотой алдааны тоо, авсан арга хэмжээ			
18	Бусад ажил			

Тайлан бичсэн хүний овог, нэр:

Албан тушаалын нэр:

Холбогдох утасны дугаар, цахим шуудан:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2024 оны 04 дугаар сарын 18-ны
өдрийн 4 дугаар тушаалын долоодугаар хавсралт



ЭМИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Үнэлгээ хийсэн огноо.....

Эмийн эмчилгээний хорооны өөрийн үйл ажиллагааг бүтэн жилээр үнэлж, тайлангийн хамт ирүүлэх.

Д/д	Үнэлэх шалгуур асуултууд	Тийм/10 оноо	Үгүй/0 оноо	Авсан оноо
1		2	3	4
Нийт авах оноо		180	0	0
Баримт бичиг				
1	Эмийн эмчилгээний хорооны зорилго, зорилт, үйл ажиллагаа болон хорооны гишүүдийн тухай мэдээллийг багтаасан бичиг баримттай байх	10	0	
2	Эмийн эмчилгээний хороонд эмнэлэгт хэрэглэх эмийн сонголтыг хийх бүрэн эрх болон эмийг сонгох тогтоогдсон шалгууртай эсэх	10	0	
3	Эмнэлгийн эмийн жагсаалттай эсэх	10	0	
4	Эмнэлгийн эмийн жагсаалтаас эмийг хасах, нэмэх мөн жагсаалтын бус эм (эмнэлгийн эмийн жагсаалтад ороогүй эм) хэрэглэх шалгуурыг боловсруулан баримтжуулдаг эсэх?	10	0	
5	Эмнэлгийн эмийн жагсаалт дахь эмүүдийн хэдэн хувийг жороор олгох эм эзэлдэг талаар мэдээллийг боловсруулан гаргасан байх	10	0	
6	Зөвхөн өөрийн эмнэлэгт хэрэглэхээр боловсруулсан эмнэлзүйн удирдамжтай эсэх	10	0	
7	Эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг үнэлэхийн тулд түүнд тусгагдсан эмийн хэрэглээний судалгааг хийсэн эсэх	10	0	
8	Эмийн эмчилгээний хороо нь эмийн талаарх мэдлэг олгох үйл ажиллагаа эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулдаг эсэх	10	0	

9	Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан номын сантай эсэх	10	0	
10	Эмийн талаарх мэдээлэл мэргэжилтнүүдэд нээлттэй ил тод байдаг эсэх	10	0	
11	Эмийн хэрэглээг зохистой болгох талаар арга хэмжээ авч, үр дүнг баримтжуулсан эсэх	10	0	
12	Хорооны хурлын давтамж, тэмдэглэл бүрэн хөтөлдөг эсэх	10	0	
Төсөв				
13	Эмийн эмчилгээний хорооны үйл ажиллагаанд зориулагдсан зардал төсөвлөгдсөн эсэх	10	0	
14	Эмийн төсөв боловсруулахад эмийн эмчилгээний хороо нь зөвлөгөө өгч, зардлыг хуваарилах үйл ажиллагаанд оролцдог эсэх	10	0	
15	Эмийн эмчилгээний хороо нь гадаад улсын эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн төлөөлөгчийн газар болон эм хангамжийн байгууллагаас өөрийн эрүүл мэндийн байгууллага дээр хийгдэж байгаа эм таниулах, сурталчлах үйл ажиллагааг зохицуулж, хянадаг эсэх	10	0	
Сургалт				
16	Эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага, мэдээлэл боловсруулсан эсэх	10	0	
17	Эмнэлгийн мэргэжилтнийг сургах тасралтгүй сургалтын тогтолцоо байгаа эсэх	10	0	
18	Хорооны гишүүдийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх дараах агуулга бүхий сургалтын хөтөлбөртэй эсэх. Үүнд - Эмийн зохистой хэрэглээ; - Эмнэлзүйн удирдамжийн сургалт - Гаж нөлөөг илрүүлэх, бүртгэх, үнэлэх, мэдээлэх - Олон улсын туршлага судлах, хамтын ажиллагаа - Бусад улс орон, байгууллагатай хамтарсан сургалт, семинар - Ажлын байран дээр ур чадвар эзэмшүүлэх; - Мэдээлэл, технологийн ашиглалт;	10	0	

	- Сургалтын үр дүнг тогтмол үнэлж, сайжруулах арга хэмжээг төлөвлөх.			
--	--	--	--	--

***Хэрэв үгүй гэж хариулсан бол шалтгааныг дурдан дэлгэрэнгүй бичиж ирүүлнэ.**

— o0o —